



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/350

Мөрөн сум

Төсөвт өртөгийн дээд хязгаар  
Батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/51 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл (Хөвсгөл)-ийн хүрээнд байгаль орчны үнэлгээ хийх, барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж угсрах, тохижуулах ажлын зураг төсөл боловсруулах, технологи, загас үржүүлгийн тоног төхөөрөмжийг сонгох, техникийн тодорхойлолт гаргах зөвлөх үйлчилгээ худалдан авах төсөвт өртгийг 70,000,000 (далан сая) төгрөгөөр тогтоосугай.

2. Зөвлөх үйлчилгээ худалдан авахад шаардлагатай 70,000,000 (далан сая) төгрөгийг Сангийн сайдын багцад батлагдсан VI.2.1.1 хуулийн дугаартай Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл (Хөвсгөл) арга хэмжээний төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т зөвшөөрсүгэй.

3. Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл (Хөвсгөл) арга хэмжээний техникийн даалгаврыг боловсруулж батлуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/253 тоот дугаартай захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

671 1010741